# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр Дугаар 622 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.4, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй боловч цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон, нийт 162,924,547.13 (нэг зуун жаран хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга таван зуун дөчин долоон төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 109,153,840.77 (нэг зуун есөн сая нэг зуун тавин гурван мянга найман зуун дөчин төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, "Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Дамдинсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн
622 дугаар тогтоолын хавсралт

**"Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Балансын үнэ /төгрөг/ | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ | Үлдэгдэл үнэ /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гүйдлийн трансформатор (110кВ) LVB-145 | 2016.06.03 | ш | 1 | 38,390,000.00 | 38,390,000.00 | 0.00 | 38,390,000.00 |
| 2 | Гүйдлийн трансформатор | 2005.10.30 | ш | 3 | 71,776,630.11 | 71,776,630.11 | 56,395,923.75 | 15,380,706.36 |
| 3 | Үйлдвэрийн акумлятор дагалдах хэрэгслийн хамт | 1997.09.01 | ком | 1 | 51,803,371.57 | 51,803,371.57 | 51,803,371.57 | 0.00 |
| 4 | Мустанг-5 мотоцикль, 72-08 УБ | 2010 | ш | 1 | 954,545.45 | 954,545.45 | 954,545.45 | 0.00 |
| | **Нийт дүн** | | | | **162,924,547.13 (нэг зуун жаран хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга таван зуун дөчин долоон төгрөг арван гурван мөнгө)** | **162,924,547.13 (нэг зуун жаран хоёр сая есөн зуун хорин дөрвөн мянга таван зуун дөчин долоон төгрөг арван гурван мөнгө)** | **109,153,840.77 (нэг зуун есөн сая нэг зуун тавин гурван мянга найман зуун дөчин төгрөг далан долоон мөнгө)** | **53,770,706.36 (тавин гурван сая долоон зуун далан мянга долоон зуун зургаан төгрөг гучин зургаан мөнгө)** |